

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ”

"KEY ISSUES TO CONSIDER IN THE HUMAN RESOURCE
DEVELOPMENT OF THE JUDICIAL ENFORCEMENT AGENCY"



Ч.Цэнд-Аюуш

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн Эрдэм шинжилгээний ажилтан-багш, ахмад

Товч агуулга: Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийг 2010-2020 онд суралцаж төгссөн (өдрийн анги) төгсөгчдийн ажил эрхлэлт, албан тушаал хашиж буй байдлыг судалж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааны бодлогод анхаарах шаардлагатай асуудлуудыг нээн илрүүлэн, цаашдын бодлого төлөвлөлтөд чиглүүлэх дүгнэлт, зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Abstract: The aim of this study is to examine the employment status and positions held by graduates (daytime program) of the University of internal affairs studying and research unit №403 school for court decision execution service who studied and graduated between 2010 and 2020, to identify key issues that need to be addressed in the human resource development policy of the Judicial Enforcement Agency, and to develop conclusions and recommendations to guide future policy and planning.

Түлхүүр үг: Их сургууль, төгсөгч, албан тушаал, боловсрол, ажил эрхлэлт, хүний нөөц, дүн шинжилгээ

Key words: University, graduate, position, education, employment, human resources, analysis

УДИРТГАЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага мөн” (УИХ У. и., 2016) гэж тодорхойлсон бөгөөд өнөөдөр үйл ажиллагаагаа Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан мэргэшсэн, чадварлаг алба хаагч буюу хүний нөөцөөрөө

дамжуулан хуулийг дээдлэн биелүүлж, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэн, төрийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлэн ажиллаж байна.

Анх 1974 онд НАХЯамны Цэргийн тусгай дунд сургууль, 1982 оноос Цэргийн дээд сургууль, 1990 оноос Цагдаагийн дээд сургууль, 2000 онд Цагдаагийн академи, 2011 онд Дотоод хэргийн их сургууль, 2012 онд Хууль сахиулахын их сургууль байгуулагдан ажилласан бүхий л хугацаанд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага боловсон хүчнээ тухайн сургуулиудад сурган бэлтгэж ирсэн байна. Судалгаанаас үзэхэд Цэргийн тусгай дунд сургуулийг 70-аад хүн, мөн 2014 оныг дуусталх хугацаанд дээд сургууль, академи, их сургуульд 1000 гаруй хүн Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэр дээр сурч төгсжээ. (Лхагваа.А, 2014)

Зарим судлаачид “... Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого нь нэг талаас хүний нөөцийн чадавхыг хадгалах, бэхжүүлэх, хөгжүүлэх зарчим, үзэл санаа, нөгөө талаас байнга хувьсан өөрчлөгдөж буй нөхцөлд тухайн цаг үед нь хариу өгөх чадвартай, мэргэшсэн алба хаагчийг бий болгох тогтолцоог ойлгож авч үздэг...” (Гантөмөр.Г, 2019) гэж зохиол бүтээлдээ дурджээ. Иймд төгсөгчдийн мэдлэг, ур чадварын асуудал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цаашдын хөгжлийн менежмент, хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарах зайлшгүй асуудлууд байгааг харуулж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-т “салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэж заасан нь агентлагийн нийтлэг чиг үүрэг бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болохынхоо хувьд боловсон хүчний бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах чиг үүргийг хэрэгжүүлж, дээд боловсролтой алба хаагчийг бэлтгэх үндсэн сургалтын байгууллага нь өнөөгийн Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль билээ.

Уг сургууль НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль, Цэргийн дээд сургууль, Цагдаагийн дээд сургууль, Цагдаагийн академийн бүтцэд “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй ба салбар эрх зүйн тэнхим”, “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхим (1996-2000 он)”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг бэлтгэх факультет (2000-2007 он)”, “Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх эрх зүйн тэнхим (2007-2011 он)”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль” (2011-2020 он) нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Дотоод хэргийн их сургууль байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229, ДХИС-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2011 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 243 дугаар тогтоол, ДХИС-ийн бүтэц, орон тоо батлах тухай ХЗДХ-ийн сайдын 2011 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 140 дүгээр тушаал гарч, уг тушаал ёсоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй ажиллахаар зохион байгуулагдсан байдаг.

ХЗДХ-ийн сайдын 2011 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 140 дугаар тушаалаар ШШГЕГ-ын 2011 оны төсвөөс 33 орон тоо, цалингийн сан, холбогдох урсгал зардлын хамт ДХИС-ийн төсөвт шилжүүлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийг шинээр байгуулжээ. (Өлзийбаатар.Д, 2024)


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар Цагдаагийн академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхимийг 2010 онд 23, 2011 онд 25 хүн суралцаж төгссөн бол тус сургууль бүрэлдэхүүн сургуулийн статустайгаар үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш буюу 2012 онд 35, 2013 онд 40, 2014 онд 30, 2015 онд 26, 2016 онд 28, 2018 онд 23, 2019 онд 44, 2020 онд 43, нийт 317 хүн суралцаж төгсжээ.

Төгсөгчдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төв орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжүүдэд томилон ажиллуулсан байдаг бөгөөд алба хаагчид тодорхой шалтгааны улмаас албанаас чөлөөлөгдөж, төрийн цэргийн болон хууль сахиулах бусад байгууллагад шилжин ажиллаж, цөөн хэдэн тохиолдолд албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдол гарсан билээ. Нийт төгсөгчдийн ажил эрхлэлт, албан тушаал хашиж буй байдалд дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

1. Алба хаагчдын ажил эрхлэлтийн байдалд хийсэн шинжилгээ:

2010-2020 онд нийт 317 иргэн суралцаж төгссөнөөс 96 төгсөгч буюу 30.3 хувь нь чөлөөлөгдөж, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад 17 төгсөгч буюу 5.4 хувь нь шилжин ажиллаж, 3 төгсөгч буюу 0.9 хувь нь нас барсан ба өнөөдрийн байдлаар 201 төгсөгч буюу 63.4 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байна.

Зураг 1. Төгсөгчдийн тоон үзүүлэлт (2010-2020 он)



Дээрх судалгаанаас харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар суралцаж төгссөн алба хаагчдын 30.3 хувь нь чөлөөлөгдсөн байгаа нь анхаарал татаж байх бөгөөд судалгааг хийх явцад одоогоор ажиллаж буй 63.4 хувийг эзэлж буй алба хаагчдын тодорхой хувь нь ямар нэгэн байдлаар албанаас чөлөөлөгдөж, эргэн томилогдсон болохыг дурдах нь зүйтэй.

2. Алба хаагчдын албан тушаалын байдалд хийсэн шинжилгээ:

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т зааснаар “Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мөн адил албан тушаалыг төрөлжүүлэн ангилсан байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар суралцаж төгссөн алба хаагчдаас өнөөдрийн байдлаар ажиллаж буй 201 төгсөгчийн хашиж буй албан тушаалын байдлыг судлан үзэхэд:

-Удирдах албан тушаал буюу ШШГЕГазрын харьяа ШШГГазар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн дарга албан тушаалд-7, ТӨУҮГазрын захирлын албан тушаалд-1, ХХГАЭДэд дарга албан тушаалд-6, Дэд бөгөөд Цагдан хорих байрны дарга албан тушаалд-9, Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн тэнхимийн профессор албан тушаалд-1 төгсөгч ажиллаж байгаа нь 11.9 хувийг эзэлж байна.

Зураг 2. Удирдах албан тушаал хашиж буй төгсөгчдийн тоон үзүүлэлт (2010-2020 он)

№	Албан тушаал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2018	2019	2020	Нийт
Удирдах												
(ШШГГазар, хэлтэс, хорих анги, салбар, нэгж)												
1	Дарга	1	4		2							7
2	Захирал				1							1
3	ХХГЭДэд дарга		2		1		2		1			6

4	Дэд бөгөөд ЦХБ-ны дарга	3	1	2	2		1					9
Дотоод хэргийн их сургууль												
1	Профессор				1							1

Гүйцэтгэх албан тушаал буюу ШШГЕГазар, түүний харьяа алба, газар, хэлтэс (ХЯЭА, ШГА, ХӨТЯЭА, ШУХТ)-ийн ахлах мэргэжилтэн албан тушаалд-12, ахлах байцаагч албан тушаалд-2, ахлах төлөөлөгч албан тушаалд-1, мэргэжилтэн албан тушаалд-6, оператив жижүүр албан тушаалд-3 төгсөгч ажиллаж байгаа нь 12 хувийг эзэлж байна.

Зураг 3. Гүйцэтгэх албан тушаал хашиж буй төгсөгчдийн тоон үзүүлэлт (2010-2020 он)

№	Албан тушаал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2018	2019	2020	Нийт
Гүйцэтгэх												
ШШГЕГ, ХЯЭА, ШГА, ХӨТЯЭА												
1	Ахлах мэргэжилтэн	1	1	5	1		2	1		1		12
2	Ахлах байцаагч			1						1		2
3	Ахлах төлөөлөгч			1								1
4	Мэргэжилтэн			2			3	1				6
5	Оператив жижүүр	1				1				1		3

ШШГЕГазрын харьяа ШШГГазар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн ахлах төлөөлөгч албан тушаалд-13, нийгмийн ахлах ажилтан албан тушаалд-3, ХХАБайцаагч албан тушаалд-5, СХНХМДАХАМэргэжилтэн албан тушаалд-2, ХӨТЯЭАХариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч албан тушаалд-1, Тасаг, хэлтсийн дарга бөгөөд Ахлах шийдвэр гүйцэтгэгч албан тушаалд-5, төлөөлөгч албан тушаалд-28, нийгмийн ажилтан албан тушаалд-7, сэтгэл зүйч албан тушаалд-2, хуяглан хүргэлтийн ажилтан албан тушаалд-6, ерөнхий жижүүр албан тушаалд-7, ээлжийн дарга албан тушаалд-18, гадна хамгаалалтын байцаагч албан тушаалд-3, ХӨТЯЭАХариуцсан шийдвэр гүйцэтгэгч албан тушаалд-8, шийдвэр гүйцэтгэгч албан тушаалд-21, ХТББайцаагч албан тушаалд-4, биеийн тамирын арга зүйч албан тушаалд-1% АТТМеханикч албан тушаалд-1, СХНХМДАХМэргэжилтэн албан тушаалд-1 төгсөгч ажиллаж байгаа нь 68.6 хувийг эзэлж байна.

Зураг 4. Гүйцэтгэх албан тушаал хашиж буй төгсөгчдийн тоон үзүүлэлт (2010-2020 он)

№	Албан тушаал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2018	2019	2020	Нийт
Гүйцэтгэх												
ШШГГазар, хэлтэс, хорих анги, салбар нэгж												
1	Ахлах төлөөлөгч		2	1	2	2	3	1	1		1	13
2	Нийгмийн ахлах ажилтан					1			1	1		3
3	Харуул хамгаалалтын ахлах байцаагч				2	1					2	5
4	СХНХМДАХАМэргэжилтэн				1	1						2
5	Ахлах шийдвэр гүйцэтгэгч /ХӨТЯЭА/									1		1
6	Ахлах шийдвэр гүйцэтгэгч /Иргэн/			1	1			3				5
7	Төлөөлөгч		1	4	3	5	1	3	3	2	6	28
8	Нийгмийн ажилтан					2		1	1	1	2	7
9	Сэтгэл зүйч										2	2
10	Хуяглан хүргэлтийн ажилтан	2	2	1	1							6
11	Ерөнхий жижүүр	1				2			1		3	7
12	Ээлжийн дарга	2	1	1	1	2		4	1	2	6	18
13	Гадна хамгаалалтын байцаагч						1			2		3
14	Шийдвэр гүйцэтгэгч /ХӨТЯЭА/	1		1						2	4	8
15	Шийдвэр гүйцэтгэгч /Иргэн/			3	2	1		2	3	6	4	21
16	ХТББайцаагч	1								2	1	4
17	Биеийн тамирын арга зүйч	1										1
18	АТТМеханик					1						1
19	СХНХМДАХАМэргэжилтэн									1		1

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ШШГСТөвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш албан тушаалд-1, Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн ахлах багш албан тушаалд-1, дамжааны захирагч-багш албан тушаалд-1, ЭЗНУС-

ийн багш албан тушаалд-1, Ахлагч мэргэжлийн боловсролын сургуулийн ШШГАТэнхимийн багш албан тушаалд-1, дамжааны захирагч багш-1 төгсөгч тус тус ажиллаж, ДХИС-ийн Удирдлагын академийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага” магистрын (өдрийн хэлбэрээр) хөтөлбөрт-4, Докторын (өдрийн хэлбэрээр) хөтөлбөрт 2 төгсөгч тус тус суралцаж байгаа нь 6.5 хувийг эзэлж байна.

Жич: Магистр, докторын хөтөлбөрт өдрийн хөтөлбөрт суралцаж буй алба хаагчдын хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гүйцэтгэх албан тушаал хашиж байсан тул тухайн ангилалд оруулсан болно.

Зураг 5. ДХИС-д ажиллаж гүйцэтгэх албан тушаал хашиж буй төгсөгчдийн тоон үзүүлэлт (2010-2020 он)

№	Албан тушаал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2018	2019	2020	Нийт
Гүйцэтгэх												
Дотоод хэргийн их сургууль												
1	Ахлах багш			1								1
2	Багш					2				1		3
3	Эрдэм шинжилгээний ажилтан-багш							1				1
4	Дамжааны захирагч-багш				1					1		2
5	Докторант			1				1				2
6	Магистрант (ДХИС-УА)			1	2	1						4

-Туслах албан тушаал буюу Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн нууцын номын санч албан тушаалд-1, хорих ангийн ХТББайцаагчийн туслах албан тушаалд-1 төгсөгч ажиллаж байгаа нь 1 хувийг эзэлж байна.

Зураг 6. Туслах албан тушаал хашиж буй төгсөгчдийн тоон үзүүлэлт (2010-2020 он)

№	Албан тушаал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2018	2019	2020	Нийт
Туслах (Ахлагч бүрэлдэхүүн)												
1	ХТББайцаагчийн туслах										1	1
2	Нууцын номын санч							1				1

ДХИС-н ЭШХүрээлэнгийн ШШГСТөвийн судлаачдын хийсэн судалгааны тайланд тусгагдсанаар ШШГБ-ын алба хаагч голчлон ямар шалтгааны улмаас ажлаас гардаг гэж үзэж байна вэ? гэсэн асуултад нийт 2701 хариултыг дугуйлснаас

а.цалин хангамж бага-561

б.гадаадад ажиллах-196

в.орон нутагт ажиллах боломжгүй-234

г.хорих байгууллагын онцлогийг ойлгоогүй-450

д.ажлын байрны дарамт их -401

е.мэдлэг, боловсролоо дээшлүүлэх-93

ё.ар гэрийн гачигдал-169

ж.ажлын ачаалал их -523

з.бусад-74 (ШШГСТөв, 2022) гэж хариулжээ.

Судалгааны явцад албанаас чөлөөлөгдсөн иргэдээс ажлаас чөлөөлөгдөх болсон шалтгааны талаар тодруулах ярилцлага хийхэд албан тушаал дэвшүүлдэггүй (төрийн албаны тухай хуульд зааснаар чадахуйн буюу мерит зарчмыг баримталдаггүй, удирдлагын хувийн үзэмжээр шийддэг), мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, сурч хөгжих боломжгүй (сургалтад явуулдаггүй, хүнээ хөгжүүлэхийг бус ажлаа л хийлгэхийг боддог), хөдөлмөрийн харилцааг хууль журамд зааснаар зохицуулдаггүй (ээлжийн амралт олгодоггүй, илүү цагаар, урт хугацаагаар ажиллуулдаг), цалин хангамж, нийгмийн баталгаа муу (аймаг, нийслэлээс алслагдсан газарт ажилладаг, нийгмийн харилцаанд бараг оролцдоггүй, цалин хангамж бусад байгууллагаас бага) зэргээс шалтгаалсан гэж байсан.

2010-2020 онд суралцаж төгссөн (өдрийн ангиар) төгсөгчдөөс өнөөдрийн байдлаар 201 төгсөгч тус байгууллагад ажиллаж байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт алба хаагчдын тоонд харьцуулахад үндсэн мэргэжилтэн болж бэлтгэгдсэн алба хаагчдын тухайд тун бага хувийг эзэлж байгааг судалгаа харуулж байна.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага боловсон хүчний бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч өөрийн үндсэн мэргэжилтэн болон бэлтгэсэн алба хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах талаар анхаарахгүй байгааг дээрх судалгаа харуулж байна гэж үзэж болох талтай.

САНАЛ

Иймд судлаачийн хувьд дараах саналыг гаргаж байна.

1.Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах замаар тогтвор суурьшилтай ажиллуулах.

2.Алба хаагчдын шилжих, дэвшин томилогдох асуудлыг удирдлагын үзэмжээр бус бодит нөхцөл байдал, чадахуйн зарчмыг баримтлан шийдвэрлэх.

3.Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу сул орон тоог нөхөх зорилгоор албан тушаалын тусгай шалгалт, сонгон шалгаруулалт зарлаж, шалгарсан иргэнийг томилж хэвших.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Гантөмөр.Г, М. Э. (2019). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэх ажлын шинэчлэлийн асуудалд. *Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замнал, хөгжлийн чиг хандлага* (хууд. 109). Улаанбаатар хот: Сэлэнгэпресс ХХК.

Лхагваа.А. (2014). *Тэнхимээс сургууль болж өргөжсөн түүхэн замнал*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг ХХК.

Өлзийбаатар.Д, Э. М. (2024). *Дотоод хэргийн их сургуулийн түүх*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг ХХК.

УИХ, У. и. (2016 оны June 09). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 257 дугаар зүйлийн 257.1 дэх хэсэг*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12701>-ээс Гаргасан

ШШГСТөв, Д.-н. Э. (2022). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт*. Улаанбаатар хот: ДХИС-н Хэвлэлийн алба.